



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Халхгол сумын музей 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/119/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд. 02.24 № 181
танай Ауд. 01.23-ны № 13 -т

「ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН」
ЯЛАЛТ МУЗЕЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ЧИНБАЯН ТАНАА

「Өөрчлөлтгүй дүгнэлт」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022063

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт музейн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 4 зорилт, 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг даргын тамгын газраас 96.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,708,797.46	76,546,786.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,440,943.96	-
35	БАРАА МАТЕРИАЛ	54,267,853.50	76,546,786.50
351	Түүхий эд материал	3,268,000.00	3,043,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,268,000.00	3,043,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	Хангамжийн материал	50,999,853.50	73,503,786.50
35410	Бичиг хэргийн материал	7,764,960.00	8,965,160.00
35420	Аж ахуйн материал	39,734,893.50	61,108,626.50
35430	Сэлбэг хэрэгсэл	70,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	2,830,000.00	2,830,000.00
35600	Мал амьтад	600,000.00	600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,261,081,904.31	1,203,393,211.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,261,081,904.31	1,203,393,211.86
391	Газар	106,000,000.00	106,000,000.00
392	Биет хөрөнгө	1,155,081,904.31	1,097,393,211.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	784,603,414.56	784,603,414.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(209,830,568.22)	(261,904,249.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,878,827.05	148,728,827.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,258,850.12)	(54,669,071.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,165,619.00	31,945,519.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,025,450.38)	(24,282,722.83)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	288,701,969.98	288,701,969.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	247,251,206.00	274,250,819.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(67,404,263.56)	(89,981,293.71)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,330,790,701.77	1,279,939,998.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	131.81
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	131.81
413	Өглөг	-	131.81
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	131.81
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,330,790,701.77	1,279,939,866.55
51	Засгийн газрын хувь оролцоо	352,789,793.00	352,789,793.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352,789,793.00	352,789,793.00
51101	Өмч: - төрийн	352,789,793.00	352,789,793.00
512	Хуримтлагдсан үр дүн	268,257,011.53	217,406,176.31
51210	Өмнөх үеийн үр дүн	276,156,893.66	268,257,011.53
51220	Тайлант үеийн үр дүн	(7,899,882.13)	(50,850,835.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	709,743,897.24	709,743,897.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,330,790,701.77	1,279,939,998.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	354,497,140.29	451,791,600.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,497,140.29	451,791,600.80
120	Нийтлэг татварын бус орлого	95,066,287.30	54,730,432.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,169,337.00	27,730,819.61
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,169,337.00	27,730,819.61
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	72,896,950.30	26,999,613.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,430,852.99	397,061,168.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,864,000.00	49,556,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	209,566,852.99	347,504,768.19
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	362,397,022.42	502,642,436.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,397,022.42	502,642,436.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,358,274.65	482,285,908.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,592,332.67	264,122,494.15
210101	Үндсэн цалин	129,609,964.07	159,758,448.74
210102	Нэмэгдэл	16,208,879.60	68,965,345.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,480,000.00	13,524,000.00
210104	Урамшуулал	17,293,489.00	21,874,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,470,343.60	33,334,300.00
210201	Тэтгэврийн даатгал	14,464,661.47	22,667,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,684,016.75	2,666,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,347,213.44	1,333,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	261,641.17	1,333,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,712,810.77	5,333,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,513,052.23	47,312,439.89
210301	Гэрэл, цахилгаан	4,487,852.23	5,756,039.89
210302	Түлш, халаалт	36,261,900.00	40,356,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,763,300.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,975,590.00	6,297,120.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	1,799,080.00
210402	Тээвэр, шатахуун	1,897,400.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	878,190.00	898,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,930,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,930,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,093,200.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	7,093,200.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,100,957.00	18,499,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,030,457.00	16,218,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	540,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	67,000.00	67,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,682,799.15	108,020,494.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,614,900.00	11,702,289.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,067,899.15	96,318,205.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,038,747.77	20,356,527.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,687,800.00	2,111,550.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,722,000.00	2,111,550.00

Дорнод аймгийн Халхгол сумын музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	9,197,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	-
2134	Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	3,350,947.77	18,244,977.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,350,947.77	18,244,977.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(7,899,882.13)	(50,850,835.22)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(7,899,882.13)	(50,850,835.22)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	281,600,189.99	424,791,987.80
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	281,600,189.99	424,791,987.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,169,337.00	27,730,819.61
120	Нийтлэг татварын бус орлого	22,169,337.00	27,730,819.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,169,337.00	27,730,819.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,430,852.99	397,061,168.19
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,864,000.00	49,556,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	209,566,852.99	347,504,768.19
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	294,257,622.27	440,232,931.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,257,622.27	440,232,931.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,218,874.50	419,876,386.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,868,649.86	264,122,494.15
210101	Үндсэн цалин	129,886,301.26	159,758,448.74
210102	Нэмэгдэл	16,208,879.60	68,965,345.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,480,000.00	13,524,000.00
210103	Урамшуулал	17,293,469.00	21,874,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,194,026.41	33,334,300.00
210201	Тэтгэврийн даатгал	14,119,976.32	22,667,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,753.62	2,666,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,337,422.91	1,333,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	271,251.76	1,333,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,793,621.80	5,333,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,513,052.23	47,312,439.89
210301	Гэрэл, цахилгаан	4,487,852.23	5,756,039.89
210302	Түлш, халаалт	36,261,900.00	40,356,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,763,300.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,818,190.00	6,297,120.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	1,799,080.00
210402	Тээвэр, шатахуун	1,115,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	903,190.00	898,040.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,258,500.00	18,278,500.00
210601	Багаж техник хэрэгсэл	7,258,500.00	16,278,500.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,093,200.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	7,093,200.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,128,817.00	16,499,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,058,317.00	14,218,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	600,000.00

Дорнод аймгийн Халхгол сумын музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	540,000.00	1,420,000.00
210807	Газрын төлбөр	67,000.00	67,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,344,439.00	31,332,472.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,344,439.00	31,332,472.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,038,747.77	20,356,545.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,687,800.00	2,111,568.19
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал	2,722,000.00	2,111,568.19
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	9,197,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,350,947.77	18,244,977.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,350,947.77	18,244,977.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(12,657,432.28)	(15,440,943.96)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(12,657,432.28)	(15,440,943.96)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,098,376.24	15,440,943.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,440,943.96	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<u>352,789,793.00</u>	<u>709,743,897.24</u>	<u>268,257,011.53</u>	<u>1,330,790,701.77</u>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<u>352,789,793.00</u>	<u>709,743,897.24</u>	<u>268,257,011.53</u>	<u>1,330,790,701.77</u>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(50,850,835.22)	(50,850,835.22)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>352,789,793.00</u>	<u>709,743,897.24</u>	<u>217,406,176.31</u>	<u>1,279,939,866.55</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		15,440,943.96	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,061,300.00	440,232,931.76	(43,171,631.76)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,949,600.00	419,876,386.04	(24,926,786.04)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,673,800.00	264,122,494.15	2,551,305.85
210101	Үндсэн цалин	168,225,000.00	159,758,448.74	8,466,551.26
210102	Нэмэгдэл	63,050,100.00	68,965,345.41	(5,915,245.41)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,524,000.00	13,524,000.00	-
210104	Урамшуулал	21,874,700.00	21,874,700.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,334,300.00	33,334,300.00	-
210201	Тэтгэврийн даатгал	22,667,300.00	22,667,300.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,666,800.00	2,666,800.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,333,400.00	1,333,400.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,333,400.00	1,333,400.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,333,400.00	5,333,400.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,556,400.00	47,312,439.89	243,960.11
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	5,756,039.89	243,960.11
210302	Түлш, халаалт	40,356,400.00	40,356,400.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	6,300,000.00	6,297,120.00	2,880.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,799,080.00	920
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,800,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	898,040.00	1,960.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,281,200.00	18,278,500.00	2,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,281,200.00	16,278,500.00	2,700.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	2,700,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	2,700,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,503,900.00	16,499,060.00	4,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,223,400.00	14,218,560.00	4,840.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	42,500.00	42,500.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,420,000.00	1,420,000.00	-
210807	Газрын төлбөр	67,000.00	67,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	31,332,472.00	(27,732,472.00)

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	31,332,472.00	(27,732,472.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,111,700.00	2,111,568.19	131.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,111,700.00	2,111,568.19	131.81
213204	Ажил олгогчоос олгох тэт, урам	2,111,700.00	2,111,568.19	131.81
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	397,061,300.00	378,816,322.47	18,244,977.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	397,061,300.00	378,816,322.47	18,244,977.53
131001	Улсын төсвөөс санхүүжих	397,061,300.00	378,816,322.47	18,244,977.53
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12	12	-
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-
620003	Үйлчлэх ажилтан	7	7	-

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 1.6 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд 300,000 төгрөгийн ширээ сандал, тавиур 1,300,000 төгрөгийн үнэ төлбөргүй орлогодож аваагүй байсныг залруулав. Энэ нь УСНББОУС 01, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 0.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.1 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2.1 Төлбөрийн акт

Шатахууны зардалд дээд шатны баталсан жишиг нормыг мөрдөөгүй 0.1 сая төгрөгийг илүү зарцуулсан нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал “Жишиг норм батлах тухай”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийг дутуу бүртгэсэн.	1	1,600.0					1	1,600.0				
Дүн	1	1,600.0					1	1,600.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардалд дээд шатны баталсан жишиг нормыг мөрдөөгүй	1	120.2					1	120.2				
Дүн	1	120.2					1	120.2				



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 46/19123799
АДА-2025/116/НА-СТА-ТМБ

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус музейн үйл ажиллагаанд ашиглагдсан тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөөгүй 120,200.00 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харъяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх", Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн тушаалын "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 1 дүгээр хавсралтанд заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" -ын шаардлага хангахгүй болон илүү зарцуулсан шатахууны зардал 120,200.00 /нэг зуун хорин мянга хоёр зуун/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Халхгол сумын музейн захирал А.Чинбаян, нягтлан бодогч Д.Алтанзаяа нарт хариуцуулав.

2125050209

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

